

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 13-ны өдөр

Дугаар

БА - 076/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 38 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 14 (арван дөрөв) агуулахтай, 16 давхар, 1 блок, үйлчилгээтэй 150 (нэг зуун тавь) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дүгээр захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 14-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/02/29 огноо, 0014540 дугаар, БАЗГ2024/0076
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ЕГ Шифр:ЭТ-6/2023
- 2.3. Захиалагч: Эзэн АСБТ ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 0000345314 регистрийн дугаар 2600927 Хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо Хүр ХК байр холбоо барих утас 80036767, 99990184 цахим хаяг;
Захиалагч: Гангар инвест ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 000018668, регистрийн дугаар 2095092 Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 5-р хороолол, Усны гудамж, 27 тоот, холбоо барих утас 99995478, 70151955 цахим хаяг; dulguun@gangar.mn
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Гранд-Оре ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, , 000179483 регистрийн дугаар, 5102138 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ16-821/23 Хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 3-р хороо баруун сэлбэ эхлэл 34 тоот холбоо барих утас, 88888188 цахим хаяг;
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Волтэйж Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 000008364 регистрийн дугаар, 5426243 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, 3Т16-795/24 Хаяг: Сүхбаатар дүүрэг 16-р хороо бэлхийн гудамж 16-390А холбоо барих утас, 99789993 цахим хаяг;

оруулах комисс

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Нэрт Ундрага Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011408049 регистрийн дугаар, 5894794 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ12-489\24 Хаяг: Улаанбаатар Баянзүрх дүүрэг 8-р хороо улаанхуаран \13301\ цагдаагийн академи 305, 3 тоот холбоо барих утас, 99012376 цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Хөлөг-Элеватор Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011144002 регистрийн дугаар, 5206561 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, ӨБ16-456\19 Хаяг: Улаанбаатар хот Хан-уул дүүрэг 2-р хороо чингэсийн өргөн чөлөө одмөнх ххк-н байр холбоо барих утас, 99098268 99119418 цахим хаяг

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Баян-Инжирт Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011400144 регистрийн дугаар, 5698464 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ11-352\22 Хаяг: Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 17-р хороо баянхошуу 29 115а тоот тоот холбоо барих утас, 88079627 цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Хөх Толгой Инженеринг ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011851574 регистрийн дугаар, 8353123 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ11-396\24 Хаяг: Улаанбаатар Баянгол дүүрэг 25-р хороо энхтайваны өргөн чөлөө го-парк 101, 83 тоот холбоо барих утас, 99097422 цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Цэлмэг Өргөө констракшн Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011852476 регистрийн дугаар, 8365202 Хаяг: Улаанбаатар Баянгол 10-р хороо 3-р хороолол 502, 18 тоот холбоо барих утас, 99064870 цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Оргих таван ган Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011322052 регистрийн дугаар, 5538823 Хаяг: Улаанбаатар Баянгол 4-р хороолол 35а-41 холбоо барих утас, 91011238

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Хасу-Инженеринг ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011430035 регистрийн дугаар, 5741939 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ12-871\22 Хаяг: Улаанбаатар Баянзүрх 12-р хороо жанжин 26, 686 тоот холбоо барих утас, 88072663 цахим хаяг

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Татах агаар ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9911358044 регистрийн дугаар, 5621526 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ17-94\19 Хаяг: Улаанбаатар Сүхбаатар 10-р хороо 7-р хороолол 10,7 тоот холбоо барих утас, 88118997 цахим хаяг

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Тэмээн Чулуут Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011814118 регистрийн дугаар, 6514391



Хаяг: Улаанбаатар Сонгинохайрхан 3-р хороо бага наран 17, 1 тоот холбоо барих утас, 99644456 цахим хаяг

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Очир Цомго групп Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9911819655 регистрийн дугаар, 6592902
Хаяг: Улаанбаатар Баянзүрх дүүрэг 22-р хороо 15-р хороолол 75, 33 тоот холбоо барих утас, 88117335, 80004799 цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Нялгын Илч ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011826565 регистрийн дугаар, 6689027 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ12-845\22 Хаяг: Улаанбаатар Баянзүрх дүүрэг 16-р хороо 16-р хороолол 28, 24 тоот холбоо барих утас, 99997111, 88583878 цахим хаяг;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Эрчим төсөл ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 0000118552 регистрийн дугаар 2614944 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар ЗТ19-117\21 Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 10-р хороо 7-р хороолол их тойруу-60\503,504,506,508 тоот холбоо барих утас 70135003, 354280 цахим

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Эзэн АСБТ ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011451059 регистрийн дугаар, 2600927 Хаяг: Чингэлтэй дүүрэг 4-р хороо Хүрд ХК байр холбоо барих утас,80036767, 99990184 цахим

Гангар орд ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистрийн дугаар, 5894794 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: тоот холбоо барих утас, цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

- 3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 14 (арван дөрөв) агуулахтай, 16 давхар, 1 блок, үйлчилгээтэй 150 (нэг зуун тавь) айлын орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос

ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

- 3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

- 3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

- 3.4 Комиссын акт 5 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 32 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

- 4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 14 (арван дөрөв) агуулахтай, 16 давхар, 1 блок, үйлчилгээтэй 150 (нэг зуун тавь) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүрэг, 38 дугаар хороо, Гангар инвест ХХК,
Эзэн-АСБТ ХХК-ийн захиалгатай, зорьтой 14 (арван дөрөв) агуулахтай, 16
давхар, 1 блок, үйлчилгээтэй 150 (нэг зуун тавь) айлын орон сууц

ГЫН
иглалтанд

Комиссын дарга: Хяналт шалгалтын
газрын Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Эзэн-АСБТ ХХК-ийн захирал



(Г.Батбилэг)

Гангар инвест ХХК-ийн ерөнхий
захирал



(Ж.Энхтөр)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.




БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 38 ДУГААР ХОРОО, ГАНГАР ИНВЕСТ ХХК, ЭЗЭН-АСБТ ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 14 АГУУЛАХТАЙ, 16 ДАВХАР, 1 БЛОК, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 150 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 14

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Гангар инвест ХХК, Эзэн-АСБТ ХХК-ийн захиалгатай, зорьтой 14 агуулахтай, 16 давхар, 1 блок, үйлчилгээтэй 150 айлын орон сууцны зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхрын 10 тоот өрөөнд 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр 13 цагт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14:30 цагт дуусав.



Хуралд:

- | | |
|---|---------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Эзэн АСБТ ХХК-ийн захирал | Г.Батбилэг |
| 3. Гангар инвест ХХК | С.Дөлгөөн |
| 4. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн улсын байцаагч | Г.Батбаатар |
| 5. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн Стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 6. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК | Д.Сүхбат |
| 7. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | Ц.Наранцацрал |
| 8. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК | Ц.Дагвадорж |
| 9. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх албны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албны менежер | Ө.Шинэцэцэг |
| 10. Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасаг | Ч.Артаг |
| 11. Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын архивын | Б.Оюунжаргал |
| 12. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл | Б.Ганбаатар |
| 14. Ашиглалт хариуцах байгууллага Гангар Орд ХХК-ийн захирал | Б.Одмаа |
| 15. Зураг төсөл зохиогч байгууллага Эрчим Төсөл ХХК-ийн архитектур | Ж.Золзаяа |
| 16. Барилгын ажил гүйцэтгэгч Гранд Оре ХХК-ийн захирал | А.Лхагва |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 16

- Хүрэлцэн ирсэн -16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 16

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Гангар инвест ХХК, Эзэн-АСБТ ХХК-ийн захиалгатай, зорьтой 14 агуулахтай, 16 давхар, 1 блок, үйлчилгээтэй 150 айлын орон сууцны зориулалттай барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч **Г.Батбаатар**

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үзүүлэх /Эрх бүхий байгууллагын шинжилгээ тооцооллын хамт/
- Зураг төслийг өөрчилж зоорийн давхар, техникийн давхарт 00 хийсэн тайлбар ирүүлэх.
- Дээврийн парпетийг хийж дуусгах.
- Техникийн давхрын ус зайлуулах хоолойг доош нь буулгах.
- Дээврийн ус зайлуулах хоолойд шүүр хийх.
- Айлуудын хоорондох тагтны тусгаарлах ханыг хийх.
- Тагтны 16 давхрын дээврийг хийх.
- Зураг төслөөр 3 давхар цонх төлөвлөсөн 2 давхар шилтэй цонх хийсэн, дулаан техникийн тооцоо ТГ сертификат үзүүлэх.
- Зоорийн давхрын цонхны шахтан хаалт хамгаалалт хийх.
- Зоорийн давхарт орох шатанд хамгаалалт хийх.
- Давхарт төлөвлөгдсөн галын төмөр хаалга хийх.
- Техникийн давхар, зоорийн давхарт айл амьдрүүлэхгүй баталгаа гаргаж өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн Стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**

- Гадна огтолгооны худагт шат, будаг, дулаалга өнгийн туузаар ороох.
- Хаалтны /огтолгоо худаг/ 2 талд ус буулгагч, агаар гаргагч угсрах.
- Зургийн дагуу дулааны 2-р худаг хийх.
- Узелийн өрөөний шугаманд хаягжуулалт, ус зайлуулах трап хийх.
- Айлуудын халаалтын коллекторт автомат хий авагч угсрах.
- Халуун усны шугамын төгсгөлт хий авагч хийх.
- Хэрэглээний усны тоолуурт хаягжуулалт, коллекторт цэврэлгээ хийх.
- Үнэр гаргагч дулаалга таг хийх.
- Гадна ус, дулаан, дотор ХАС, ЦБУ ил далд ажлын акт шалгуулах.
- Халаалтын босоо шугамуудад даралт тохируулагч хаалт хийх.
- Айлуудын босоо шугаманд давхар алгасаад үзлэгийн ревиз гаргах.



- Айлуудын халаах хэрэгсэлд термостат угсрах.
- Агаар сэлгэлтийн ердийн системд багажаар хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах.
- 1-р давхарт АС-ийн механик систем зургийн дагуу угсрах.
- Хог нөөцлөх сав гадна талбайд байрлуулах.
- Нийслэлийн авто замтай гадна цэвэр, бохир усны зураг зөвшилцсөн эсэхийг шалгуулах.
- Гадна ус, Дулаан хангамж мэдээллийн санд оруулах.
- Техникийн давхрын өрөөг айл өрхөөр ашиглахгүй баталгаа гаргах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах**

- Айл хоорондын тагтны тусгаарлах ханыг зураг төслийн дагуу хийх.
- Цонхны 2 давхар шиллэгээн дээр зохиогч байгууллага дулаан техникийн тооцоо гаргаж, хангаж байгаа эсэх талаар тайлбар албан бичиг ирүүлэх.
- Цоколийн давхарт цонхонд зураг төслийн дагуу решетка хийх.
- Дээврийн заслын ажил, дотуур усны хаялганы хог шүүгч, техникийн давхрын усны буулт тагтны дээврийн засал, парпетны ажлуудыг бүрэн дуусгах.
- Суурь болон зоорийн давхрын хананд ус тусгаарлагч хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх.
- Барилгын тухай хуулийн 5.7-д заасны дагуу норм нормативын төлбрийг тооцуулж төлөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК **Ц.Дагвадорж**

- Дотор холбоо дохиоллын актуудын гарын үсэг гүйцэт зуруулах.
- Домофон системийг ажиллуулах.
- Дотор холбоо дохиоллын ажлыг зургийн дагуу зоорийн давхарт хяналтын камер суурилуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх албны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албны менежер **Ө.Шинэцэцэг**

- УСУГ-аас олгосон 282/23 тоот техникийн нөхцлийн дагуу усны нөөцийн савыг зураг төсөлд тусгаагүй, угсраагүй.
- Цэвэр усны тоолуурын лацыг тасалсан тул яаралтай баталгаажуулах, тоолууруудыг зөв байрлалд байрлуулах.
- 282/23 тоот техникийн нөхцөлд гадна цэвэр усны худагт галын гидрант суурилуулах гэсэн шаардлагыг яаралтай гүйцэтгэж гадна огтолгоонд гидрант суурилуулах.
- Гадна огтолгооны хаалтыг филанзан хаалтаар солих / яаралтай аваарын үед бөмбөлгөн хаалт шаардлага хангахгүй болно/

- СУХ-н стандартын дагуу угсрах 1.Шатыг хөдөлгөөнгүй угсрах 2.уналтыг худгийн трап дээр угсрах 3.дулааны тагыг сайжруулах 4.Худгуудыг цэвэрлэх.
- Цэвэр усны шинжилгээ өгөх.
- Хөрс борооны усыг БУШугамд нийлүүлэхгүй байх баталгаа албан бичиг ирүүлэх.
- Цэвэр усны худагт шат хийх, шугамыг дулаалах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК **Ц.Наранцацрал**

- 15/01839/23 техникийн нөхцлийн дагуу 4 кабель татсан холболтын протокол.
- Ерөнхий Щитний өрөө батлагдсан зургаас зөрсөнг зургийн авторын дүгнэлтэд хүчин чадлын хамт дэлгэрэнгүй тусгуулах.
- Узелийн өрөөний тоноглолын суурийг газардуулгын хүрээтэй холбож гагнах.
- Аянга хүлээн авагч хийх.
- Нийтийн эзэмшил дулаагны узельд тус тусад нь ухаалаг тоолуур тавих.
- ТН-ийн 4.10 заалтын биелэлтийг хангуулах.
- Газраа чөлөөлсөн айл өрхийн ЦЭХ-ний гэрээг цуцлуулсан баримт.
- Барилга баригдах үеийн цахилгааны төлбөр тооцоог хийж барагдуулсан байх.
- Давхар дундын Щит дэх айл өрхийн дотрох автоматуудыг хөдөлгөөнгүй бэхлэнэ.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн хэлтсийн дарга **Д.Сүхбат**

- Халаах хэрэгсэлд тохируулах винтель тавих.
- Гадна дулааны худагт шат болон ус буулгагч хийх.
- Холигч узельд автомат хаалт датчиг суурилуулах.
- Хаягжуулалт хийх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасаг **Ч.Артаг**

- Техникийн давхарт батлагдсан зургийн дагуу засах.
- Зоорийн давхраас техникийн давхар хүртлэх гонхонд батлагдсан зургийн дагуу хаалга бүрэн хийж дуусгах.
- Холбоо дохиоллыг бүрэн хийж дуусгах, зоорийн давхарт дутуу.
- 1-р давхарт зургийн дагуу гонхонд хаалт хаалга хийх.
- Галын дотор усны даралтад цэгийн холбох тотыг гал унтраах багаж зэвсэглэлтэй болгож болхоор тооцож солих /16-р давхарт даралтыг хэмжих/
- Өгсөн үүрэг даалгаврыг албан бичиг болон фото зургаар өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Б.Ганбаатар**

- Нийтийн авто зогсоолд ХБХ-н машинд зориулсан зогсоолын өргөн 3м95см тооцож хийнэ. Машин зогсох зай 2м45см тэргэнцэртэй бууж суух зай

1м50см өргөн шугам татаж тусгаарлаж өгнө.Зогсоолын урд 1м80см шон 30*45см багагүй самбар хийнэ.

- Явган замруу гарсан брожурын налуу градусыг 6 градусаас ихгүй болгож налуу болгох.
- Үйлчилгээний зориулалттай бш заалны угаалтуур, суултуурт БНБД 31-23-22 стандартын шаардлага хангасан туслах тоноглолыг суурилуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Гангар Орд ХХК /ашиглалт хариуцсан байгууллага/ **Б.Одмаа**

- Дулааны худагт шат, дулаалга гүйцэт хийх, юүлэгч тавих.
- Узелийн өрөөнд траф хийх, юүлэгч дутуу, агааржуулалт хийх.
- Бохирын худагт орох шатыг дүрмийн дагуу тавих
- Гаргалгааны шугамыг дахин буулгаж хийх.
- Тоолуурын хаягжуулалт хийх.
- Узелийн өрөөний цахилгааныг нийтийн эзэмшилд салгаж тоолуур тавих.
- Халуун усны төгсгөлд автомат хий авагч хийх.
- Узелийн шугам хоолойн хаягжуулалт хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Эрчим Төсөл ХХК /зураг төсөл зохиогч/ **Ж.Золзаяа**

- Барилгын орцны галын хаалгыг нөхөж заавал хийх шаардлагатай
- Дээврийн ажлыг гүйцээж хийх.
- Тагтны хооронд хийх өрлөг хаалтыг хийх шаардлагатай.
- Дутуу ажлуудыг хийж дуусгах, дээврийн парпед хана дуусгах.
- Зоорийн давхарт айл байрлахаар өрөөнүүд хийсэн байна болиулах.
- Зоорийн давхрын хаалга цонхонд хаалт заавал хийх.
- Хөтөч болон чиглүүлэгч хавтан байхгүй байна.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Эзэн-АСБТ ХХК-ийн захирал Комиссын нарийн бичгийн дарга **Г.Батбилэг**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Гангар Инвест ХХК Комиссын нарийн бичгийн дарга **С.Дөлгөөн**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Гранд Оре ХХК Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага **А.Лхагва**

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Үндэсний төв архивын газар, Зураг төслийн баримтын архивч **Б.Оюунжаргал**

- Архивд баримтаа баримт бүрдүүлэх нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх.
- Хувийн хэрэгт дотоод товъёг хийж бүрэн бүрдэлтэй өгөх.
- БҮ-н тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулах гарын үсэг бүрдэл ханган хуудас дугаарлах ажлын нэрээр хаяглалт хийх
- БҮ-н ил далд ажлын акт зурагт дотоод товъёг хийж эх хувиар өгөх.

- Барилгад хэрэглэсэн бараа материалыг тусад нь хэрэг бүрдүүлж дотоод товьёг хийж өгөх.
 - Ажлын зургийн зургийн бүрдлийн дагуу бүрэн бүрдэлтэй эх хувиар өгөх /нүүр хуудас хийж хуудас дугаарлах/
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.


Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- БНБД-ийн дагуу зохиогч нэгдсэн дүгнэлтийг эцэслэн бичих.
- БТХ-ийн дагуу гүйцэтгэгч чанарын баталгааны албан тоот ирүүлэх.
- Дээврийн парпет төмрийг гүйцээх.
- Усны хаялгыг доош буулгах.
- Чиглүүлэгч хавтанг норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэх.
- “Е” сууцны 2 айлын тагтыг тусгаарлах аюулгүй байдлыг хангах.
- Техникийн давхар болон зоорийн давхарт айл амьдруулахгүй гэсэн албан бичиг захиалагчаас ирүүлэх.
- В1 давхрын цонхонд хаалт хийх усанд автхаас сэргийлэх.
- ЗГ-ын 2021 оны 212 тогтоолын 8.1 дэх заалтыг чанд баримтлах.
- Хүүхдийн тоглоомын талбайг стандартын дагуу хийх хугацаа заасан албан тоот ирүүлэх.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Гангар инвест ХХК, Эзэн-АСБТ ХХК-ийн захиалгатай, зорьтой 14 агуулахтай, 16 давхар, 1 блок, үйлчилгээтэй 150 айлын орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Эзэн-АСБТ ХХК-ийн захирал



(Г.Батбилэг)

Гангар инвест ХХК-ийн ерөнхий
захирал

(Ж.Энхтөр)